

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ ЖУРМЫН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН  
НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 5 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

**1. Журам гаргах үндэслэл, шаардлага, зорилт**

Журмыг боловсруулах үндэслэл нь “Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурал 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэнтэй холбоотой болно. Уг хуулийн шинэчилсэн найруулгаар төмөр замын тээврийн аюулгүй байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, төрийн байгууллагын бүрэн эрх, төмөр замын тээврийн байгууллага, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалтыг шинэчлэн тодорхойлсон.

Түүнчлэн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтад “төмөр замын тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах журам” байхаар, мөн 11.2 дахь хэсэгт уг журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тус тус заасан.

Иймд төмөр замын тээврийн осол, зөрчлийг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэх, мэдээллийн сан хөтлөх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг шинэчилсэн хуультай нийцүүлэн зохицуулах зорилгоор энэхүү журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан болно.

Журмыг шинэчлэн боловсруулах практик шаардлага нь “Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар “осол, гологдол” гэсэн нэр томъёог “осол, зөрчил” болгон өөрчилж, төмөр замын тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн тодорхойлсонтой холбоотой болно. Мөн шинэчилсэн найруулгад үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам эзэмшигч гэсэн шинэ зохицуулалтын субъект нэмэгдсэнтэй холбоотойгоор осол, зөрчлийг мэдээлэх, ангилах, шинжлэн шалгах, бүртгэх үйл ажиллагаанд хамрах хүрээ өргөжсөн. Түүнчлэн төмөр замын тээврийн осол, зөрчлийг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэх үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалттай болгох, байгууллага хоорондын ойлголт, хэрэгжилтийн зөрүүг арилгах, осол, зөрчлийн шалтгаан, шалтгаан, нөхцөлийг тогтоох, аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгох шаардлага үүссэн.

Одоогийн мөрдөгдөж байгаа “Төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам”-д хэрэглэж байгаа “гологдол” гэсэн ойлголт нь бусад хууль тогтоомжид хэрэглэж байгаа нэр томъёо, эрх зүйн ойлголттой нийцэхгүй, практикт ойлголтын зөрүү үүсгэж байна. Тухайлбал “гологдол” ангилалд төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлсөн ноцтой зөрчил, түүнчлэн байгууллагын дотоод ажиллагаатай холбоотой зарим ажлын алдаа, дутагдлыг хамруулан хэрэглэж байгаа нь осол, зөрчлийн ангилал, үр дагаврыг ялгамжтай үнэлэх, бүртгэх, хариуцлага тооцох ажиллагаанд хүндрэл үүсгэж байна.

Мөн мөрдөгдөж байгаа журам нь “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомжийн зохицуулалттай бүрэн уялдаагүйгээс осол, зөрчлийг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх, хяналт шалгалтын ажиллагааг хэрэгжүүлэхэд ойлголт, хэрэглээний зөрүү гарах нөхцөл бүрдэж байна.

Түүнчлэн төмөр замын тээврийн гаднын нөлөөлөлтэй холбоотой осол, зөрчил, дутагдлыг төмөр замын салбарын хэмжээнд нэгдсэн байдлаар бүртгэж, судалдаггүй, цагдаагийн байгууллагын бүртгэлээр хязгаарлагдаж ирсэн нь статистик, мэдээллийн сан хангалтгүй байх, шалтгаан, нөхцөлийг салбарын хэмжээнд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ төлөвлөх боломжийг хязгаарлаж байна.

Олон улсын болон иргэний нисэхийн салбарын осол, зөрчил шинжлэн шалгах жишиг, чиг хандлагад хараат бус, мэргэшсэн шинжлэн шалгах тогтолцоо, байнгын ажиллагаатай мэргэжлийн баг ажиллуулах, шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд үндэслэн тайлан, дүгнэлт, аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэж байна. Иймд төмөр замын салбарт осол, зөрчлийг мэргэжлийн, төвлөрсөн зохион байгуулалтаар шинжлэн шалгах, мэргэшсэн багийг үе шаттайгаар бүрдүүлэх, шинжлэн шалгах тайлан, зөвлөмжийн тогтолцоог хөгжүүлэх шаардлага үүссэн.

Эдгээр асуудлыг шийдвэрлэснээр төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэх ажиллагааны нэгдсэн тогтолцоо бүрдэж, осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг үнэн зөв тогтоох, статистик, мэдээллийн санг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, сайжруулах нөхцөл бүрдэнэ.

Журмын зорилго нь төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулах, осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, цаашид дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, сайжруулахад оршино.

Журмын төслөөр дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
2. Осол, зөрчил, дутагдлыг ангилах, бүртгэх, мэдээлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;
3. Осол, зөрчил, дутагдлын шалтгаан, нөхцөлийг үнэн зөв тогтоох, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох;
4. Осол, зөрчил гарсан үед шуурхай мэдээлэх, нотлох баримтыг хамгаалах, шинжлэн шалгах ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
5. Төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн эрх, үүрэг, оролцоог тодорхой болгох;
6. Осол, зөрчлийн мэдээллийн сан, бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, төмөр замын тээврийн аюулгүй байдлын дүн шинжилгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;
7. Гадаад орны болон зам, тээврийн салбарын осол, зөрчил шинжлэн шалгах үйл ажиллагааны сайн туршлага, аргачлалыг нэвтрүүлэх;
8. Осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгахтай холбоотой нэр томъёо, ойлголтыг нэгдсэн байдлаар хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх;
9. Төмөр замын тээврийн гаднын нөлөөлөлтэй холбоотой осол, зөрчил, дутагдлыг бүртгэх, судлах, дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;

10. Осол, зөрчил шинжлэн шалгах мэргэжлийн, төвлөрсөн, үе шаттай хөгжүүлэх тогтолцооны суурийг бүрдүүлэх.

## **2. Журмын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Журмын шинэчилсэн найруулгын төсөл нь дараах 7 бүлэгтэй. Үүнд:

1. Ерөнхий зүйл;
2. Осол, зөрчил, дутагдлын ангилал;
3. Осол, зөрчил, дутагдлыг мэдээлэх;
4. Осол, зөрчил, дутагдлыг шинжлэн шалгах;
5. Осол, зөрчил, дутагдлыг бүртгэх;
6. Осол, зөрчил, дутагдлыг олон нийтэд мэдээлэх;
7. Хяналт, хариуцлага.

Журмаар төмөр замын тээврийн байгууллага, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэх, тайлан гаргах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Журмын хамрах хүрээ нь төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой үйл ажиллагаанд хамаарна.

1. Журмын төслийн 1 дүгээр бүлэгт журмын зорилго, хамрах хүрээ, нэр томьёо, осол, зөрчил, дутагдлыг шинжлэн шалгах үйл ажиллагааны үндсэн зарчим, шинжлэн шалгах ажиллагааны чиглэл, тайлангийн зорилго, дахин ангилах, нэмэлт болон дахин шинжлэн шалгахтай холбоотой нийтлэг зохицуулалтыг тусгасан.

2. Журмын төслийн 2 дугаар бүлэгт төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлын ангилал, осолд хамаарах, зөрчилд хамаарах, дутагдалд тооцох тохиолдол, гаднын нөлөөлөлтэй холбоотой үйл явдлыг ангилан тодорхойлох зохицуулалтыг тусгасан.

3. Журмын төслийн 3 дугаар бүлэгт осол, зөрчил, дутагдлыг шуурхай болон бичмэлээр мэдээлэх, мэдээлэл хүргүүлэх хугацаа, хэлбэр, хамрах байгууллага, албан тушаалтны зохицуулалт, түүнчлэн осол, зөрчил, дутагдлын нэгдсэн мэдээллийг төрийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

4. Журмын төслийн 4 дүгээр бүлэгт осол, зөрчил, дутагдлыг шинжлэн шалгах ажиллагааны зарчим, зохион байгуулалт, шинжлэн шалгах баг, шинжээч, улсын байцаагчийн оролцоо, эрх, үүрэг, осол, зөрчил гарсан үед төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нотлох баримтыг хамгаалах, тайлан боловсруулах, нууцлал, мэдээллийн хамгаалалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

5. Журмын төслийн 5 дугаар бүлэгт төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг бүртгэх, осол, зөрчлийн ангиллыг эцэслэн тогтоох, улсын хэмжээнд нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан хөтлөх, гаднын нөлөөлөлтэй холбоотой үйл явдлыг тусад нь ангилан бүртгэх, холбогдох баримт материалыг хадгалахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

6. Журмын төслийн 6 дугаар бүлэгт осол, зөрчил, дутагдлын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд мэдээлж болох болон задруулахыг хориглох мэдээллийн хүрээ, ноцтой үр дагавартай ослын талаарх мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагаас нэгдсэн байдлаар мэдээлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

7. Журмын төслийн 7 дугаар бүлэгт журмын хэрэгжилтэд тавих хяналт, холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүрэг, энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

## **2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлэг**

Энэхүү журмын төсөлтэй холбоотойгоор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэгт төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч иргэн, хуулийн этгээд, тээвэрлэгч, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, төмөр замын хөдөлгөөн зохион байгуулалт, ашиглалт, засвар үйлчилгээ, техникийн хяналт, аюулгүй ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа эрхэлж байгаа ажилтан, албан тушаалтан, шинжээч, улсын байцаагч, осол, зөрчил шинжлэн шалгах ажиллагаанд оролцогч бусад этгээд хамаарна. Мөн осол, зөрчлийн улмаас хохирол хүлээсэн иргэн, хуулийн этгээд, төмөр замын тээврийн аюулгүй байдал, орчны нөлөөлөл, нийтийн ашиг сонирхолтой холбоотой харилцаанд оролцогч бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж болзошгүй.

Энэхүү журмын төсөл нь ялгаварлан гадуурхсан, эсхүл аль нэг бүлэг, хүйс, иргэн, хуулийн этгээдэд давуу байдал үүсгэсэн зохицуулалт агуулаагүй бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт тусгаагүй болно. Журмын төсөлд тусгагдсан зохицуулалт нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах нийтлэг зорилгод чиглэсэн бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан болно.

Энэхүү журмын төсөл нь төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой нийтлэг зохицуулалтыг тусгасан бөгөөд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөөлөх, хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдөл бий болгох, аль нэг аж ахуйн нэгжид давуу болон сул нөхцөл үүсгэх зохицуулалт агуулаагүй болно. Мөн шинээр зах зээлд оролцогч аж ахуйн нэгжид нэмэлт бэрхшээл, хүндрэл бий болгохгүй бөгөөд төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах нийтлэг шаардлагыг адил тэгш хэрэгжүүлэхэд чиглэсэн болно.

Энэхүү журмын төсөл нь төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой зохион байгуулалт, ажиллагааны зохицуулалтыг тусгасан бөгөөд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай хэт нэмэлт ачаалал үүсгэхгүй болно. Журмын төсөлд тусгагдсан зохицуулалт нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг тогтоох зохицуулалт агуулаагүй бөгөөд төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн болно. Мөн хэрэглэгчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй бөгөөд осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг үнэн зөв тогтоох,

урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулснаар төмөр замын тээврийн аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах нөхцөл бүрдэнэ.

Энэхүү журмын төсөл нь төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой зохион байгуулалт, ажиллагааны зохицуулалтыг тусгасан бөгөөд хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй болно. Харин осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны явцад нотлох баримтын бүрэн бүтэн байдлыг хангах, мэдээллийн нууцлалыг хамгаалах, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тодорхой мэдээллийг түр хугацаанд хязгаарлах зохицуулалт тусгагдсан бөгөөд энэ нь хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд хэрэгжинэ.

Энэхүү журмын төсөл нь төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой зохион байгуулалт, ажиллагааны зохицуулалтыг тусгасан бөгөөд эдийн засаг, нийгмийн харилцаа, аж ахуйн үйл ажиллагаанд саад, хориг учруулах зохицуулалт агуулаагүй болно. Харин төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг үнэн зөв тогтоох, цаашид дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шуурхай мэдээлэх, нотлох баримтыг хамгаалах, шинжлэн шалгах ажиллагаанд хамтран ажиллахтай холбоотой үүргийг холбогдох байгууллага, этгээдэд хүлээлгэж байгаа болно.

Энэхүү журмын төсөл нь төмөр замын тээврийн осол, зөрчил, дутагдлыг ангилах, мэдээлэх, шинжлэн шалгах, бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааны дараалал, оролцогч байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхой тусгасан бөгөөд аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн зохицуулалт агуулаагүй болно. Түүнчлэн осол, зөрчлийг мэдээлэх хугацаа, шинжлэн шалгах ажиллагааны үе шат, тайлан боловсруулах, бүртгэх, мэдээлэх ажиллагааг тодорхой болгосноор байгууллага, албан тушаалтны хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн болно.

Төмөр замын тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгахтай холбоотой харилцааг “Төмөр замын тээврийн тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”, “Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний актад Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар баталсан “Төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам” хамаарч байгаа бөгөөд энэхүү журмын шинэчилсэн найруулгын төслийг “Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэн боловсруулсан болно.

### **3. Журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо**

Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигчийн одоо ажиллаж байгаа албан хаагч, шинжээч, улсын байцаагч, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалт, техникийн хяналт, дотоод хяналт, шуурхай удирдлага хариуцсан ажилтнууд оролцоно. Журмыг хэрэгжүүлэхэд шинээр орон тоо бий болгох шаардлагагүй бөгөөд холбогдох байгууллагын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой.

Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон төмөр замын тээврийн байгууллагын одоо ашиглаж байгаа холбоо мэдээллийн хэрэгсэл, бүртгэл, мэдээллийн сан, дотоод хяналт,

шуурхай удирдлагын тогтолцоог ашиглан хэрэгжүүлэх боломжтой. Журмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын төсвөөс нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй бөгөөд холбогдох байгууллагууд өөрийн батлагдсан төсөв, орон тоо, техник хэрэгслийн хүрээнд хэрэгжүүлнэ.

Цаашид осол, зөрчил шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн хүний нөөц, арга зүй, сургалтын тогтолцоог үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай.

-----o0o-----